



МОНГОЛ УЛС  
БАЯНХОНГОР АЙМГИЙН ЗАСАГ ДАРГЫН  
ЗАХИРАМЖ

2021 оны 05 сарын 11 өдөр

Дугаар А/293

Номгон

Техникийн хяналтын үзлэг, тээврийн хэрэгслийн  
албан татвар хураалтын ажлыг зохион  
байгуулах тухай

“Автотээврийн тухай” хуулийн 7 дугаар зүйлийн 7.1.1 дэх заалтыг үндэслэн  
ЗАХИРАМЖЛАХ нь:

1.Тээврийн хэрэгслийн техникийн хяналтын 2021 оны ажлыг зохион  
байгуулах аймгийн комиссыг нэгдүгээр, сумдад ажиллах комиссыг хоёрдугаар,  
үзлэгийн хуваарийг гуравдугаар хавсралтаар тус тус баталсугай.

2. Орон нутагт техникийн хяналтын үзлэгийн үйл ажиллагааг явуулах үед  
сумын Эрүүл мэндийн төв, Цагдаа, Онцгой байдлын болон бусад төрийн  
байгууллагуудын оролцоотойгоор хүн амын дунд коронавирусын халдвар  
тархахаас урьдчилан сэргийлэх чиглэлээр бүхий л арга хэмжээг авч, үйлчилгээний  
газруудад бөөгнөрөл үүсгэхгүй байхаар зохион байгуулж, төлбөр тооцооны цахим  
хэлбэрийг нэн тэргүүнд ашиглаж, үйлчлүүлэгчдэд түргэн шуурхай үйлчилгээ  
үзүүлэхийг Автотээврийн төв /С.Амармөнх/, сумдын Засаг дарга нарт даалгасугай.

3. Техникийн хяналтын үзлэгийн үйл ажиллагааг жилийн турш, холбогдох  
стандартуудын шаардлагыг хангуулсны үндсэн дээр чанартай зохион байгуулж,  
тээврийн хэрэгслийн бүртгэл, хасалтыг хийж, аймгийн Татварын хэлтэс, сумдын  
Засаг даргын Тамгын газар, сум дундын Цагдаагийн тасаг, Цагдаагийн хэсэг,  
багийн Засаг дарга нартай хамтарч ажиллахыг Автотээврийн төв /С.Амармөнх/-д  
үүрэг болгосугай.

4.Тус аймгийн иргэд, байгууллагын эзэмшилд бүртгэлтэй байгаа  
автотээврийн болон өөрөө явагч хэрэгслийн албан татвар, агаарын бохирдлын  
төлбөр, орон нутгийн автозам ашигласны төлбөр хураамжийг холбогдох хууль,  
тогтоомжид заасны дагуу хураан авч төсөвт төвлөрүүлэхийг аймгийн Татварын  
хэлтэс /С.Рэнцэндагва/-т үүрэг болгосугай.

5. Сумынхаа албан байгууллага, иргэдийн болон нутаг дэвсгэртээ үйл  
ажиллагаа явуулж байгаа уул уурхайн байгууллагуудын тээврийн хэрэгслийг

521012745


2.

техникийн хяналтын үзлэг, албан татвар төлөлтөд бүрэн хамруулахыг сумдын Засаг дарга нарт даалгасугай.


6. Техникийн хяналтын үзлэгт хамрагдсан байдал, автотээврийн болон өөрөө явагч хэрэгслийн албан татвар, орон нутгийн автозам ашигласны төлбөр төлөлт, жолоочийн хариуцлагын албан журмын даатгалд даатгагдсан байдалд бүтэн жилийн турш хяналт шалгалтыг тасралтгүй хийж, зөрчлийг тухай бүр арилгуулахыг Мэргэжлийн хяналтын газар /Н.Бямбадорж/, Цагдаагийн газар /Б.Оюутболд/, Автотээврийн төв /С.Амармөнх/ нарт үүрэг болгосугай.

7. Техникийн хяналтын үзлэг, тээврийн хэрэгслийн албан татвар хураалтыг орон нутагт зохион байгуулсан дүн мэдээг үндэслэн сумдын Засаг дарга нарын үр дүнгийн гэрээнд үнэлэлт дүгнэлт өгч ажиллахыг Засаг даргын Тамгын газрын Хяналт шинжилгээ үнэлгээ дотоод аудитын хэлтэс /Г.Төртогтох/-д даалгасугай.

8. Техникийн хяналтын үзлэг, албан татвар хураалтын үйл ажиллагаанд хяналт тавьж ажлын үр дүнг улирал тутам танилцуулж ажиллахыг Комиссын дарга /С.Амармөнх/-д, захирамжийн хэрэгжилтэд хяналт тавьж ажиллахыг Засаг даргын орлогч /Б.Батсуурь/ нарт тус тус үүрэг болгосгай.

ДАРГА  Д.МӨНХСАЙХАН

Аймгийн Засаг даргын 2021 оны 05 дугаар  
сарын 11-ний өдрийн А/293 дугаар захирамжийн  
1 дүгээр хавсралт



ТЕХНИКИЙН ХЯНАЛТЫН ҮЗЛЭГ ЯВУУЛАХ АЙМГИЙН  
КОМИССЫН БҮРЭЛДХҮҮН

С. Амармөнх -Автотээврийн төвийн дарга

Д.Магвансүрэн-Мэргэжлийн хяналтын газрын Байгаль орчин, дэд бүтэц,  
хөдөлмөрийн хяналтын хэлтсийн дарга, улсын ахлах байцаагч

А.Батхуяг-Цагдаагийн газрын Замын цагдаагийн тасгийн дарга


Т.Энхмандах – Аймгийн Татварын хэлтсийн Орлогын тасгийн дарга

А.Дорж-Аймгийн Засаг даргын Тамгын газрын Хөрөнгө оруулалт, хөгжлийн  
бодлого төлөвлөлтийн хэлтсийн Тээвэр, автозам хариуцсан мэргэжилтэн

М.Хаш-Эрдэнэ-Албан журмын даатгагчдын холбооны Баянхонгор аймаг  
дахь салбарын менежер

\_\_\_\_\_оОо\_\_\_\_\_

Аймгийн Засаг даргын 2024 оны 05 дугаар  
сарын 11-ний өдрийн А/293 дугаар захирамжийн  
2 дугаар завсралт



**ТЕХНИКИЙН ҮЗЛЭГ ЯВУУЛАХ САЛБАР  
КОМИССЫН БҮРЭЛДХҮҮН**

Сумдад ажиллах комисс:

Д.Баттулга - Автотээврийн төвийн Техникийн хяналтын үзлэгийн инженер

Б.Ганболд-Автотээврийн төвийн Тээвэр, бүртгэлийн мэргэжилтэн

Ч.Балжинням-Автотээврийн төвийн Техникийн хяналтын үзлэгийн техникч

Сумын Засаг даргын захирамжаар томилогдсон салбар комисс /Татварын  
улсын байцаагч, сум дундын Цагдаагийн тасгийн дарга, хэсгийн төлөөлөгч, цагдаа,  
багийн Засаг дарга нар/

\_\_\_\_\_оОо\_\_\_\_\_

Аймгийн Засаг даргын 2021 оны 05 дугаар  
сарын 11-ний өдрийн А/293 дугаар захирамжийн  
3 дугаар хавсралт

### ТЕХНИКИЙН ХЯНАЛТЫН ҮЗЛЭГ ЯВУУЛАХ ХУВААРЬ

№	Сум, багийн нэр	Хоног	Хугацаа
1	Баянхонгор аймгийн төв		01 дүгээр сарын 04-нөөс 5 дугаар сарын 14
<b>Говийн чиглэл</b>			
2	Жинст	2	5 дугаар сарын 17-ноос 05 дугаар сарын 18
3	Богд	2	5 дугаар сарын 19-нөөс 05 дугаар сарын 20
4	Баянлиг	3	5 дугаар сарын 21-нээс 05 дугаар сарын 23
5	Баянговь	3	5 дугаар сарын 24-нөөс 05 дугаар сарын 28
6	Шинэжинст	2	5 дугаар сарын 27-ноос 05 дугаар сарын 28
7	Баян-Өндөр	2	5 дугаар сарын 29-нөөс 05 дугаар сарын 30
8	Баянцагаан	3	5 дугаар сарын 31-нээс 06 дугаар сарын 02
9	Баацагаан	2	6 дугаар сарын 03-наас 06 дугаар сарын 04
10	Баянхонгор аймгийн төв		6 дугаар сарын 07-ноос 06 дугаар сарын 11
11	Алтны уурхайд ажиллах		6 дугаар сарын 12-ноос 06 дугаар сарын 13
12	Өлзийт	2	6 дугаар сарын 14-нөөс 06 дугаар сарын 15
<b>Хангайн чиглэл</b>			
13	Баян-Овоо	1	6 дугаар сарын 16
14	Эрдэнэцогт	2	6 дугаар сарын 17-ноос 06 дугаар сарын 18
15	Шаргалжуут /Баянхонгор сум/	1	6 дугаар сарын 19
16	Бөмбөгөр	2	6 дугаар сарын 21-нээс 06 дугаар сарын 22
17	Бууцагаан	3	6 дугаар сарын 23-наас 06 дугаар сарын 25
18	Хүрээмарал	1	6 дугаар сарын 26
19	Баянбулаг	2	6 дугаар сарын 27-ноос 06 дугаар сарын 28
20	Гурванбулаг	1	6 дугаар сарын 29
21	Заг	2	6 дугаар сарын 30-наас 07 дугаар сарын 01
22	Жаргалант	2	7 дугаар сарын 02-ноос 07 дугаар сарын 03
23	Галуут	2	7 дугаар сарын 04-нөөс 07 дугаар сарын 05
24	Баянхонгор аймгийн төв		7 дугаар сарын 07-ноос 12 дугаар сарын 30
	Сумдад ажиллах нийт хоног	42	

\_\_\_\_\_оОо\_\_\_\_\_